

БАТЛАВ
СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН
ПРОРЕКТОР *Д.Заяабаатар* Д.ЗАЯАБААТАР

МУИС-ИЙН 2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН

"НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ" ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго: МУИС-д шинээр элсэн суралцаж буй оюутнуудад сургалт, оюутны хөгжлийн үйл ажиллагаа, суралцагчийн соёл, сургалтын орчин болон оюутныг дэмжих үйлчилгээг танилцуулах, зөвлөмж, зөвлөгөө өгөх, олон нийтэд мэдээлэл хүргэж танилцуулах, МУИС-ийн клубүүдийн үйл ажиллагааг олон нийт, оюутан залууст сурталчлах, клубийн шинэ элсэлт тэдний үйл ажиллагааг сурталчлан танилцуулах, өргөжүүлэхэд чиглэгдэнэ.

Хамрах хүрээ: МУИС-д шинээр элсэн суралцагчид, тэдний эцэг эх, Оюутны хөгжлийн газар, Сургалт, хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын газар, МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд, оюутны байгууллага, клубүүд болон хамтрагч байгууллагууд оролцоно.


Хугацаа: 2026 оны 09 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд

I. "НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ"

(2026.09.15-нд 10:00-16:00 цагт)

"Нээлттэй өдөрлөг"-ийн хүрээнд оюутнуудад чиглэсэн үйлчилгээ, сургалт, хөгжлийн боломж, мэдээлэл зөвлөгөөг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлж, МУИС-ийн Холбогдох нэгж, төв, бүрэлдэхүүн сургуулиуд, оюутны байгууллага болон хамтрагч байгууллагуудын үйл ажиллагааг танилцуулна. Өдөрлөгт оролцогчид "Нээлттэй өдөрлөгийн аялал" картаар өдөрлөгийн асар, мэдээллийн цэгүүдээр зочлон өөрт хэрэгтэй мэдээлэл, зөвлөгөөг авах бөгөөд картад оролцоогоо баталгаажуулна.

1.1. Өдөрлөгийн асар, мэдээллийн цэгүүд



Асар №	Үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1	Эхлэх цэг	Өдөрлөгийн үйл ажиллагааны ерөнхий танилцуулга хийх, "Нээлттэй өдөрлөгийн аялал" картыг олгох, оролцогчдод өдөрлөгийн зохион байгуулалт болон маршрутын талаар мэдээлэл өгөх
2	Номын сан	Номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээ, ашиглах боломжийн талаар танилцуулга, зөвлөгөө, мэдээлэл хүргэх; ном, бүтээгдэхүүний худалдаа зохион байгуулах
3	МУИС пресс брэнд дэлгүүр	МУИС-ийн брэнд бүтээгдэхүүний танилцуулга, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, худалдаа үйлчилгээ үзүүлэх
4	Бүрэлдэхүүн сургуулийн тэнхим, лаборатори	Бүрэлдэхүүн сургуулиудын тэнхим, лабораторийн үйл ажиллагаа, сургалт, судалгааны орчин, боломжийг танилцуулах; үзэсгэлэн зохион байгуулах
5	Хамтрагч байгууллагууд- (Оюутанд чиглэсэн үйлчилгээ, боломжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх)	• Боловсролын зээлийн сан • Худалдаа хөгжлийн банк
6		• Голомт банк • Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
7		• МУИС-ийн IELTS төв • Ард даатгал
8		• GGI cosmetics (арьс оношилгоо) • Golden gym фитнесс
9		• Хаан банк • MCS Coca cola
10	NUM career (Карьер хөгжлийн зөвлөгөө өгөх)	Оюутны карьер хөгжлийг дэмжих үйлчилгээ, ажил мэргэжлийн чиг

		баримжаа, хөгжлийн боломжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх
11	МУИС-ийн оюутны байгууллага, клубүүдийн мэдээлэл	Оюутны холбоо, сайн дурын болон бусад оюутны байгууллага, клубүүдийн үйл ажиллагаа, элсэлт, оролцооны боломжийн талаар мэдээлэл өгөх
12	Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газар	Хичээл, сургалтын үйл ажиллагаа болон хөтөлбөртэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх
	Цахим шилжилтийн газар	Оюутны сиси мэдээллийн системтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл өгөх
13	Оюутны хөгжлийн газар	Оюутанд чиглэсэн үйлчилгээ, хөгжлийн боломжийн танилцуулга хийх, оюутны үнэмлэх тараах хэсэг
		“Нээлттэй өдөрлөгийн аялал”-аа бүрэн дуусгасан оролцогчдод бэлэг олгох, МУИС-ийн музейн үзмэр болон кампустай танилцуулах

1.2. Нээлттэй өдөрлөгийн талаар мэдээлэл өгөх цэг

Нээлттэй өдөрлөгийн үеэр доор дурдсан хичээлийн байруудад өдөрлөгийн үйл ажиллагаа, байршил болон хөтөлбөрийн талаарх мэдээлэл, зөвлөгөөг өгч ажиллана. Үүнд:

Асар байрлах байршил	Хичээлийн 4,5-р байр
	Хичээлийн 8-р байр
	Хичээлийн 7-р байр
	Хууль зүйн сургуулийн хичээлийн байр

1.3. Зохион байгуулалт


МУИС-ийн 2026–2027 оны хичээлийн жилийн “Нээлттэй өдөрлөг”-т Оюутны хөгжлийн газар болон холбогдох бусад нэгж, төвүүд үйл ажиллагааны чиглэл, үйлчилгээ, мэдээ мэдээллээ бэлтгэн хамтран оролцоно.

Өдөрлөгийн үеэр оюутнуудад шаардлагатай мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлж, асар бүрд чиглүүлэн ажиллах, мэдээлэл өгөх болон оролцоог баталгаажуулах зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

II. “МУИС-ИЙН ОЮУТНЫ КЛУБУУДИЙН ӨДӨРЛӨГ-2026”

(2026.09.16-нд 10:00-16:00 цагт)

Зорилго: МУИС-ийн 84 дэх хичээлийн жилд оюутны байгууллага, клубүүдийн үйл ажиллагааг олон нийт, оюутан залууст сурталчлах, клубийн шинэ элсэлт тэдний үйл ажиллагааг сурталчлан танилцуулахад чиглэгдэнэ.



2.1. Өдөрлөгийн үеэр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газар болон цахим шилжилтийн газар хичээл, сургалтын үйл ажиллагаа болон оюутны сиси мэдээллийн системтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл өгөх;
- Оюутны байгууллага, клубүүдийн бодлого чиглэл, үйл ажиллагаа, үйлчилгээг сурталчлах
- Оюутнуудын санал, санаачилга, зөвлөмжийг хүлээн авч, цаашдын үйл ажиллагаанд тусгах;
- Оюутны байгууллага, клубүүдийн үйл ажиллагаанд суралцагчдыг идэвхтэй оролцуулах;
- Клубүүдэд шинээр гишүүн элсүүлэх, сонирхсон оюутнуудад мэдээлэл, зөвлөгөө өгөх;
- Урлагийн клубүүдийн уран бүтээл, үзүүлбэрийг танилцуулах.

2.2. Хөтөлбөр

№	Хугацаа	Үйл ажиллагаа	Тайлбар
1	10:00-12:00	Өдөрлөг эхлэх	Өдөрлөгт оролцож буй газар, нэгж, оюутны байгууллага, клубүүд асартаа үйл ажиллагааны танилцуулгаа эхлүүлнэ. Оюутнуудад клубийн үйл ажиллагаа, элсэлт, оролцооны боломжийн талаар мэдээлэл өгөх
2	12:00-14:00	Мэндчилгээ	МУИС-ийн оюутны урлагийн клубүүдийн мэндчилгээ, уран бүтээлийн үзүүлбэрийг хүргэх

3	14:00-16:00	Өдөрлөгийн үндсэн арга хэмжээ	Клубүүдийн танилцуулга урлагийн клубүүдийн бэлтгэсэн хөтөлбөр, үзүүлбэрүүд зохион байгуулагдах
---	-------------	-------------------------------	--



2.3. Зохион байгуулалт

“МУИС-ийн оюутны клубүүдийн өдөрлөг–2026”-ийн үйл ажиллагааг холбогдох нэгж, төв, бүрэлдэхүүн сургууль, оюутны байгууллага, клубүүд болон хамтрагч байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Өдөрлөгийн бэлтгэл ажил, оролцогч байгууллагуудын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, мэдээлэл сурталчилгаа, талбайн зохион байгуулалт болон өдөрлөгийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр зохион байгуулах комисс ажиллана.

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС